



ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЦАХИМ ХЭРЭГЛЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН

Улаанбаатар хот
2025 он



ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЦАХИМ ХЭРЭГЛЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН

Судлаач С.Баттулга

Улаанбаатар хот
2025 он

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЦАХИМ
ХЭРЭГЛЭЭТЭЙ ХОЛБООТОЙ
ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН
МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН**

Судлаач С.Баттулга

Цаасны хэмжээ: А5

Хэвлэлийн хуудас: 1.25 х.х

Дизайнер: Ж.Халиунцэцэг

ГАРЧИГ

Удиртгал.....	4
Мониторинг хийх хэрэгцээ, үндэслэл	4
Мониторингийн хамарсан хүрээ	5
Мониторингийн зорилго	6
Мониторингийн хэрэгжилт	6
Тохиолдсон хүндрэл, бэрхшээл.....	7
Үндсэн үр дүнгүүд	8
Мониторингийн нэгтгэсэн үр дүн	8
Багш нарын цахим судалгааны үр дүн	10
Олон улсын плафторм, системүүдийн зардлын тооцоо	14
Өнөөгийн байдал	14
Цаашид шаардагдах зардлын тооцоо (жил бүр).....	15
Санал, зөвлөмж.....	17
Санал.....	17
Цаашид анхаарах асуудлууд	18



МОНИТОРИНГ ХИЙХ ХЭРЭГЦЭЭ, ҮНДЭСЛЭЛ

Засгийн газрын 2024 оны 8 сарын 28-ны өдрийн 53 дугаар тогтоолын дагуу ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээний 1.62-1.97%-ийг цахим хэрэглээний зардалд хуваарилах болсон.¹ Өмнө нь 2022 оны 3 сарын 2-ны өдрийн 91 дүгээр тогтоолд цахим хэрэглээний зардлыг нийт хувьсах зардлын 1%-тай тэнцүү байхаар анх удаа тусгасан байдаг /одоо хүчингүй болсон/. Үүнээс өмнө багш нар өөрсдийн цалин хөлсөөс илүүчлэн дата авч цахим хэлбэрээр хичээлээ зааж, сурагчдтайгаа холбоотой байдаг гэх гомдол тасардаггүй байсан юм. Ялангуяа Ковид-19 цар тахлын үеэр хичээл сургалтын үйл ажиллагаа бүхэлдээ цахим болон зайн хэлбэрээр зохион байгуулагдаж байсан тул хөдөлгөөнт интернетийн үйлчилгээ, сургалтын удирдлагын мэдээллийн систем, цахим контентын хэрэглээ, программ хангамжийн ашиглалтын зардал зэргийн санхүүжилтийг 2022 оноос эхлэн сургуулийн төсөвт олгох болсон. Гэвч уг төсөв хүрэлцэхгүй байгаа тул багш нар өөрсдийн цалин хөлснөөс цахим хэрэглээнд зарцуулсаар байгаа тухай яригдсаар байна.

Сүүлийн үед сургалтын удирдлага мэдээллийн систем хөгжиж байгаа нь нэг талаас суралцахуйн удирдлагыг хялбар болгож, мэдээлэл солилцоог сайжруулж байгаа сайн талтай ч нөгөө талаас төрөл бүрийн платформ, аппликэйшнд төлөх төлбөр, хураамжийг нэмэгдүүлж сургуулийн төдийгүй эцэг эх, асран хамгаалагчдын өрхийн төсөвт ачаалал үүсгэж болзошгүй байна. Тиймээс сургуулиуд ямар мэдээллийн системүүд ашиглаж, хэдий хэмжээний төлбөр, хураамжийг сургуулийн төсвөөс төлж байгаа болон эцэг эх, асран хамгаалагчдаас ямар нэгэн төлбөр гаргуулж байгаа эсэхийг тодруулах хэрэгтэй байгаа юм.

Сүүлийн 2 хичээлийн жилд Pearson English, Eduten зэрэг лицензийн төлбөртэй олон улсын хөтөлбөрийн платформуудыг ерөнхий боловсролын

1 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141293183621>

сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлж эхэлсэн бөгөөд удахгүй Монгол Улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Энэ нь боловсролын салбарын төсвийн багагүй хэсэг эдгээр хөтөлбөрийн лицензийн төлбөрт зарцуулагдаж байгаа бөгөөд цаашид уг хэсэг улам бүр нэмэгдэх төлөвтэй байгааг илтгэж байгаа юм. Боловсролын салбарын төсөвт ирэх дарамт ихээхэн нэмэгдэх үед нэг бол хөтөлбөрүүдийг зогсоох, үгүй бол эцэг эх, асран хамгаалагчдаас лицензийн төлбөрийг гаргуулахаас өөр аргагүй байдалд хүрч болзошгүй байна.

Тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардал Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын дагуу нийт хувьсах зардлын 4-15% байхаар анх заасан бол Засгийн газрын 2024 оны 8 сарын 28-ны өдрийн 53 дугаар тогтоолоор нийт хувьсах зардлын 2.31-14%-тай тэнцэх болсон. Уг нөхөн хангалтын төсвийн хүрэлцээ, тулгарч буй бэрхшээлийг тодруулж, илүү үр ашигтай ашиглахын тулд юуг яаж өөрчлөх хэрэгтэй байгааг мөн илрүүлэх шаардлагатай байсан.

МОНИТОРИНГИЙН ХАМАРСАН ХҮРЭЭ

Мониторингт сургуулийн дараах төрлийн төсвийн зарцуулалтыг хамарлаа. Үүнд:

1. Сургуулийн цахим хэрэглээний төсөв, төсвийн зарцуулалт
2. Сургуулийн интернетийн төлбөр, сургалтын удирдлага мэдээллийн системийн төлбөр, хураамж гэх зэрэг цахимтай холбоотой бусад төсөв, төсвийн зарцуулалт

Дээрхээс гадна

1. Лицензтэй олон улсын хөтөлбөрт зарцуулж буй төсөв (боловсролын салбарын урсгал зардлын төсвөөс)
2. Багш нарын цахим хэрэглээний нийт зардал (өөрийн цалин хөлсөөс зарцуулж байгааг оролцуулаад)
3. Эцэг эх, асран хамгаалагчдаас гаргуулж буй сургалтын удирдлага мэдээллийн системийн төлбөр, хураамж (хэрэв байвал) зэргийг мөн судалсан.

Цаг хугацааны хувьд мониторинг сүүлийн 3 төсвийн жил буюу 2022-2024 оныг хамарсан болно.

МОНИТОРИНГИЙН ЗОРИЛГО

- ЕБС-ийн цахим хэрэглээ, нөхөн хангалтын төсвийн хүрэлцээ, зарцуулалт, тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг илрүүлэх
- Интернет үйлчилгээний ашиглалт, сургалтын удирдлага мэдээллийн системийн ашиглалтын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг илрүүлэх
- Багш нар цахим хэрэглээнд өөрсдөөсөө мөнгө гаргасаар байгаа эсэх
- Олон улсын хөтөлбөрийн платформ, системүүдийн ашиглалтын зардлын дунд хугацааны тооцоолол хийх зэрэг байв.

Мониторингийн үр дүнд үндэслэн хувьсах зардал, боловсролын төсөвтэй холбоотой зохих санал, зөвлөмж дэвшүүлэхийг мөн зорьсон болно.

МОНИТОРИНГИЙН ХЭРЭГЖИЛТ

Мониторингийн арга зүйг 2024 оны 12 дугаар сард боловсруулсан бөгөөд 2025 оны 2 дугаар сард нийслэлийн 120 болон 21 дүгээр сургууль дээр боловсруулсан арга зүйг туршиж, шаардлагатай сайжруулалтыг хийсэн.

2025 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр Эвслийн гишүүн байгууллага, салбар зөвлөл, сургуулийн Үйлдвэрчний эвлэлийн төлөөллөөс бүрдсэн судлаачдын дунд арга зүйн сургалтыг зохион байгуулсан. Улмаар 2025 оны 4 болон 5 дугаар сард нийслэлийн 29, орон нутгийн 25, нийт 54 сургуулиас мэдээлэл цуглуулж, нэгдсэн тайланг боловсрууллаа.

Мониторингийн хүрээнд сургуулийн захирал, нягтлан бодогчтой уулзалт хийж, 3 төрлийн маягтаар тоон мэдээлэл цуглуулсан болно. Мөн 54 сургуулийн нийт 2,386 багшаас мониторингийн сэдэвтэй холбоотой цахим судалгаа авав.

Урьдчилсан үр дүн, санал болон зөвлөмжийн төслийг 2025 оны 7 дугаар сарын 4-ний өдөр Боловсролын яам, Боловсролын ерөнхий газрын албан хаагчдад танилцуулсан болно.

ТОХИОЛДСОН ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ

Захирал, нягтлан бодогчид мэдээлэл өгөхөөс цааргалах нь түгээмэл байсан. Сургуулийн нягтлан бодогч эзгүй байснаас (өвчтэй, эмнэлэгт хэвтсэн, жирэмсний амралт авсан, түр ажиллаж байгаа, сургалттай, хот явсан гэх мэт шалтгаанаар) мэдээлэл цуглуулах хугацаа сунжирсан. Захирал тохирсон цагт очиход ажилтай, өвчтэй зэрэг шалтгаанаар уулзалтын цагаа хойшлуулах, өөрчлөх тохиодол ч хэд хэд гарсан.

Сургуулиуд санхүүгийн тайлангаа хэвлэж өгөх хүсэлгүй байсан нь төсвийн нээлттэй, ил тод байдал муутгах, иргэдийн оролцоог хязгаарлах үр дагавартай гэдгийг мөн тэмдэглэе.

ҮНДСЭН ҮР ДҮНГҮҮД



МОНИТОРИНГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮН

Сургуулиудад цахим хэрэглээний зардлын төсөв өгдөг болсон нь сайшаалтай ч хэрэгцээ их байгаа тул **хүрэлцээ тааруу байна**. Сурагчийн тооноос хамаарч төсөв ирж байгаа тул **цөөн сурагчтай сургуулиудын хувьд төсвийн хүрэлцээ илүү муу байна**. Гэвч тэдгээр сургуульд интернет үйлчилгээ авах, ухаалаг самбартай болох, цахим ангитай болох зэрэг хэрэгцээ, шаардлага бусад сургуулийн л нэгэн адил бий.

Зарим тохиолдолд **юунд зарцуулж болох, болохгүй тухай удирдамж, чиглэл дээд шатнаас тодорхой ирдэггүй** тул зарцуулалт дээр эргэлзээ үүсч байна. Жишээлбэл, багш нарт дата авч өгч болно, болохгүй ч юмуу нөхөн хангалтын зардлын төсвөөс хатуу эдлэл /ширээ, сандал гэх мэт/ авч болно, болохгүй гэх зэрэг асуудал дээр бичгээр маш тодорхой удирдамж, чиглэл тухай бүрт нь цаг алдалгүй өгч баймаар байна гэсэн санал цөөнгүй гарсан.

Хэдийгээр интернет үйлчилгээний чанар, хүртээмж сайжрах хандлагатай байгаа ч **ихэнх сургуулийн багш, сурагчид өөрсдөө дата авч холбогдох шаардлагагүй түвшинд очоогүй л байна**. Илүү ноцтой нь **сургуулийн байршил, хичээлийн байрны тоо зэргээс шалтгаалж сургуулиудын интернет үйлчилгээний хүртээмж, чанар ялгаатай байна**. Хэдийгээр нийслэл, аймгийн төвийн сургууль мөн боловч төвөөс алслагдсан байршилтай сургуулиудын хувьд сүлжээний тасралтгүй байдал, хурд ихээхэн асуудалтай байгаа нь ажиглагдлаа. Түүнчлэн **мэдээллийн технологийн мэргэжлийн ажилтан сургуульд байдаггүй** нь интернет, дотоод сүлжээ, цахим тоног төхөөрөмжийн ашиглалттай холбоотой асуудлуудыг үр дүнтэй шийдвэрлэж чадахгүй байхад нөлөөлж байна.

Сургалтын удирдлагын мэдээллийн систем /СУМС/-ийн ашиглалт ихэнх сургуулийн хувьд багш нар сурагчдын ирц бүртгэх, гэрийн даалгавар өгөх, дүн оруулах зэргээр хязгаарлагдаж байна. Эцэг эх, асран

хамгаалагчид төдийлөн ашиглаж эхлээгүй байна. Одоогоор эцэг эх, асран хамгаалагчдаас сургалтын удирдлага мэдээллийн системийн ашиглалттай холбоотойгоор ямар нэгэн төлбөр, хураамж авсан тохиолдол гараагүй. Зарим системд сургуулийн номын сангийн програмыг холбох боломжтой байтал номын санд ашиглагдах өөртөө үйлчлэх киоск нь байхгүйгээс /худалдаж авъя гэхээр төсөв хүрэлцэхгүй, цахим дэлгүүрт байхгүй/ СУМС-ийн ашиглалт муу байх жишээтэй. Өөрөөр хэлбэл системийн боломжуудыг бүрэн ашиглаж чадахгүй байна.

Бүх сургууль Pearson English, Eduten зэрэг лицензийн төлбөртэй олон улсын хөтөлбөрийн платформуудыг хичээл, сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тулгарч байгаа гол бэрхшээл нь **цахим анги, таблет болон нөүтбүүкийн хүрэлцээ, хангамж муу, интернетийн хурд удаан** зэрэг асуудлууд байна. Сурагчид өөрсдийн гар утсаараа платформуудад хандсан хэвээр байна. Тэр тохиолдолд ухаалаг гар утас, төхөөрөмжгүй сурагчдад суралцахуйн хоцрогдол үүсэх эрсдэл байна. Ялангуяа Эдүтэн платформоор гэртээ очиж хийх даалгавар өгөгдсөн үед ухаалаг гар утас, төхөөрөмжгүй болон интернетгүй сурагчид даалгавраа хийж чадалгүй ирж байна. Түүнчлэн **эцэг эх, асран хамгаалагчид 1, 2 -р ангийн сурагчид цахим платформоор суралцахад төдийлөн таатай хандахгүй байгаа** талаар сургуулиуд хэлж байсан. Өөр нэг ноцтой асуудал гэж таблет, нөүтбүүк, хромбүүк зэрэг **цахим тоног төхөөрөмжийн эрүүл ахуй, ариун цэврийг сургуулиуд хөндөж байв**. Учир нь тэдгээрийн хүрэлцээгүй байдлаас болж тэднийг цахим ангидаа төвлөрүүлсэн байдаг бөгөөд 5 минутын зайтай л сурагчид солигдон тоног төхөөрөмжийг ямар ч ариутгал, нөхөж сэлбэх байтугай цэнэглэх боломж ч олгохгүй ашиглаж байна. Энэ нь тэдгээрийн ашиглалт, эдэлгээнд мөн сөргөөр нөлөөлж байна.

Нөхөн хангалтын зардлын төсвийг ихэвчлэн цахим анги байгуулах, цахим тоног төхөөрөмж авах зэргээр зарцуулж байна. Ихэнх сургуулиуд хүрэлцээтэй гэж хэлээгүй ч өмнө нь байдаггүй байсан тул ийм төсөвтэй болсондоо талархалтай байна. Энд **гол бэрхшээл нь цахим дэлгүүрт байна** гэж судалгааны үр дүнгээс харагдлаа. Тодруулбал, цахим дэлгүүрт байгаа барааны нэр төрөл цөөн /сонголт муутайгаас гадна гал тогооны тоног төхөөрөмж, ширээ сандал зэрэг эд байдаггүй гэж сургуулиуд хэлжээ/, үнэ өндөр /жишээ нь ухаалаг дэлгэц цахим дэлгүүрт 15 сая төгрөг гэж байхад зах зээл дээр 8 сая төгрөг байсан/, чанар муутай /компьютер зэрэг тоног төхөөрөмжийн хэвийн ашиглалтын буюу элэгдүүлэх хугацаа 5 жил байдаг байхад 1-2 жил болоод эвдэрч, ашиглах аргагүй болж байгаа эд ч

байна/. Ихэнх сургууль цахим дэлгүүрийн барааны нэр төрөл, үнэ, чанарыг сайжруулах үгүй бол сургуулиудад худалдан авалтын эрхийг олгохыг хүсч байсан.

БАГШ НАРЫН ЦАХИМ СУДАЛГААНЫ ҮР ДҮН


Манай цахим судалгаанд нийт 2,386 багш хамрагдсан. Үүний 786 буюу 32.9% нь бага ангийн багш байв.

Зураг 1. Судалгаанд хамрагдсан багш нарын бүтэц



Бид багш нараар сургуулийнх нь хөдөлгөөнт интернетийн үйлчилгээ (wifi)-г дараах 3 үзүүлэлтээр үнэлүүлж, үр дүнг нь дараах зурагт харуулав.


Зураг 2.Хөдөлгөөнт интернетийн үйлчилгээний үнэлгээ



Дээрх үр дүнгээс үзэхэд хүртээмжтэй байдалтай харьцуулахад тасалдалгүй байдал, хурд гэсэн үзүүлэлт тааруу үнэлэгдсэн байна.

Судалгаанд хамрагдсан багш нар сургуулийнхаа цахим дэд бүтэц, орчныг хэрхэн үнэлсэнийг дараах зургаас харна уу.

Зураг 3.Цахим дэд бүтэц, орчны үнэлгээ



Үнэлгээний үр дүнгээс үзэхэд багш нар компьютер, таблет зэрэг цахим хэрэгслээр харьцангуй хангагдсан байдалтай байгаа бол цахим анги, танхим болон сурагчдын цахим хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.


Багш нарын 2,078 буюу 87.1% нь дата авах зэргээр цахим хэрэглээндээ өөрсдөөсөө зардал гаргасаар байгааг манай судалгааны үр дүн харуулсан. Тодруулбал, тэдний 620 буюу 29.8% нь 10-20 мянган төгрөг, 607 буюу 29.2% нь 20-30 мянган төгрөг тус тус зарцуулж байна.

Зураг 4. Багш нарын цахим хэрэглээндээ зарцуулж буй зардал, төгрөг



Багш нар уг мөнгийг юунд зарцуулж байгааг тодруулахад, өөртөө дата авдаг болон хичээлдээ ашигладаг программ, аппликэйшны төлбөр төлдөг гэсэн хариулт зонхилсон байна.

Зурар 5.Багш нарын цахим хэрэглээний зарцуулалт, давхардсан тоогоор



Багш нараас өмнө нь өгч байсан 15,000 төгрөгийн цахим хэрэглээний дэмжлэгийг үргэлжүүлэх хэрэгтэй эсэхийг асуухад тэдний **2,155 буюу 90.3% нь үргэлжлүүлэн олгохыг дэмжсэн** гэдгийг энд тэмдэглэе.

ОЛОН УЛСЫН ПЛАФТОРМ, СИСТЕМҮҮДИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Боловсролын цахим шилжилтийн хүрээнд Математикийн хичээлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах, сурагчдын асуудал шийдвэрлэх, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор Финлянд улсын Турку их сургуулийн “Эдүтэн” математик сургалтын олон улсын жишигт нийцсэн цахим системийг Монгол Улсын ерөнхий боловсролын сургуулиудад хэрэгжүүлэхээр Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/312 дугаар тушаалаар шийдвэрлэсэн. Энэхүү системийг төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 3-4 дүгээр ангид хэрэглэж эхэлсэн бөгөөд 2023 онд 857,396,628 төгрөг зарцуулсан. 2024-2025 оны хичээлийн жилд тус системийн ашиглалтын зардалд хамрагдаж буй суралцагчийн тоогоор тооцон суралцагч нэг бүрд 2.99 евротой тэнцэх зардал, нийт 341,950 суралцагчийн зардалд 1,472,946,096.08 төгрөгийг төлсөн байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны “Цахим системд суурилсан англи хэлний хөтөлбөр хэрэгжүүлэх, төлөвлөгөө батлах тухай” А/353 дугаар тушаалаар англи хэлний цахим системд суурилсан Пийрсон англи хэл (Pearson English) хөтөлбөрийг төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудад хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталсан. Тус тушаалын дагуу хөтөлбөрийн лицензийн төлбөрт 2023-2024 оны хичээлийн жилд 4,780,478,181 төгрөг, 2024-2025 оны хичээлийн жилд 2,860,792,000 төгрөг тус тус төлөгджээ. 2024-2025 оны хичээлийн жилийн мэдээгээр уг хөтөлбөрт төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 5-7 дугаар ангийн 202,951, туршилтын 104 сургуулийн 3-4 дүгээр ангийн 37,161, ерөнхий боловсролын 38 сургуулийн 8-11 дүгээр ангийн 19,960, нийт 260,072 суралцагч хамрагдсан байна.

Ерөнхий боловсролын сургуулийн 6-12 дугаар ангийн суралцагчдын математикийн хичээлийн сурлагын хоцрогдлыг арилгахад дэмжлэг үзүүлэх зорилгоор үндэсний контент хөгжүүлэгч болох “Сураад” ХХК-ийн “Сураад.мн” цахим системийг сонгогдсон ерөнхий боловсролын 141 сургуулийн 38,540 сурагчийг хамруулан хэрэгжүүлэхэд 2022-2024 онд нийт 888,146,225 төгрөг зарцуулжээ.

2022 онд Боловсрол, шинжлэх ухааны сайд “Шаардлага батлах тухай” А/111 дүгээр тушаалаар “Боловсрол сургалтын байгууллагын болон суралцахуйн удирдлагын системд тавих шаардлага /LMS, SMS/”, А/370 дугаар тушаалаар “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль/дотуур байрны хоол үйлдвэрлэл, үйлчилгээний системд тавих шаардлага”-ыг тус тус баталснаар боловсрол сургалтын байгууллага, суралцахуйн удирдлагын систем дээр 4, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний систем дээр 5 аж ахуйн нэгжтэй ерөнхий гэрээ байгуулагджээ. 2022-2024 онд 530 гаруй ерөнхий боловсролын сургууль дээрх системүүдээс сонголттойгоор ашиглаж, хувьсах зардлын цахим хэрэглээний зардлын төсвөөс 8.3 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Дээрх зардлуудыг нэгтгэн авч **үзэхэд 2022-2024 онд дээр дурдагдсан платформ, системүүдийг ашиглахад нийтдээ 19.2 тэрбум төгрөг буюу боловсролын салбарын урсгал зардлын 0.1-0.3%-ийг зарцуулжээ.**

ЦААШИД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО (ЖИЛ БҮР)

2024-2025 оны хичээлийн жилийн сурагчийн тоо, нэг сурагчид ногдох зардлын мэдээллийг ашиглаж, олон улсын хөтөлбөрийн платформ болон системүүдийн ашиглалтад цаашид жил бүр ямар хэмжээний төлбөр төлөхөөр байгааг тооцоолж, үр дүнг нь доор хүснэгтэд харуулав.

Хүснэгт 1. Олон улсын хөтөлбөрийн платформ болон системийн ашиглалтын зардлын тооцоо

Платформ/систем	Хамрагдах сурагчийн тоо	Шаардагдах төсвийн төсөөлөл, төгрөг	Тайлбар
Эдүтэн	275,046	3,016,632,630.98	2-5 дугаар ангийн бүх сурагч платформыг ашиглана гэж үзсэн /нэг сурагчийн зардал 2.99 евро/
Пийрсон англи хэл	588,093	6,469,023,000.00	3-12 дугаар ангийн бүх сурагч хөтөлбөрт хамрагдана гэж үзсэн
Сураад.мн	378,469	8,721,738,807.20	6-12 дугаар ангийн бүх сурагч хамрагдана гэж үзсэн
LMS/SMS	-	2,766,666,666.67	Өнгөрсөн 3 жилийн хугацаанд төлөгдсөн нийт төлбөрийн дунджаар тооцсон
Нийт		20,974,061,104.84	
Боловсролын салбарын урсгалд зардалд эзлэх хувь		0.72%	Өнгөрсөн 3 жилийн Боловсролын сайдын багцын урсгал зардлын төсвийн дундажид эзлэх хувь

Эх сурвалж: Боловсролын яамны тоон дээр үндэслэсэн судлаачийн тооцоолол

Эдүтэн хөтөлбөрөөр 2-5 дугаар ангийн бүх сурагч, Пийрсон англи хэлний хөтөлбөрөөр 3-12 дугаар ангийн бүх сурагч хичээллэж, Сураад.мн цахим системийг 6-12 дугаар ангийн бүх сурагч хэрэглэн, ерөнхий боловсролын сургуулиуд сургалтын байгууллага, суралцахуйн удирдлагын системийг өнөөгийн түвшинд ашигласаар байх нөхцөлд **жил бүр 21 тэрбум орчим төгрөгийн зардал гарах төлөвтэй байна.** Энэ нь өнгөрсөн 3 жилийн хугацаанд гарсан зардал болох 19.2 тэрбум төгрөгтэй харьцуулахад нэлээд нэмэгдэж болзошгүй зардал бөгөөд боловсролын салбарын урсгал зардалд эзлэх хувь наад зах нь 2 дахин ихсэхээр байгаа тул санхүүжилтийн эх үүсвэрийг оновчтой төлөвлөж, бүрдүүлэхэд цаашид анхаарах хэрэгтэй байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ



САНАЛ

Цахим хэрэглээний зардлын төсөв, нөхөн хангалтын зардлын төсвийн зарцуулалтын талаар дээд шатны байгууллагаас өгөх чиглэл, удирдамжийг нэгж байгууллагад тухай бүрт нь, шуурхай, нэгдсэн байдлаар, давтамжтай өгөх /улирал тутам/: захирал, нягтлан бодогч нар өөрчлөгдөнө, шинээр томилогдоно. Тэр бүрийд өмнө нь хэлж, ярьсан гээд чиглэл, удирдамж өгөхгүй байгаад байж болохгүй. Энэ тал дээр Боловсролын газрын үүрэг, оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна /тэд зөвхөн хянаж шалгах биш, зөвлөн туслах чиг үүрэгтэй/.

Цахим сургалт, цахим хэрэглээ, мэдээллийн технологиос хамаарах хамаарал нэмэгдэж байгаа өнөө үед сургуулиудад орон тооны мэдээллийн технологийн ажилтан ажиллуулах: бүх багш нар интернет холболт, сүлжээний доголдол, системийн ашиглалттай холбоотой асуудлуудын учрыг олж чадахгүй бөгөөд чаддаг байх ч боломжгүй юм. Гэтэл сургууль дээр сүлжээний хурд унах, тасрах, цахим тоног төхөөрөмжүүд ажиллахгүй байх зэрэг асуудлууд өдөр тутам гарч байгаа ч үр дүнтэй шийдэж чадахгүй байна. Энэ нь мэдээллийн технологи, системийн боломжуудыг бүрэн ашиглаж чадахгүй байх, эвдэрсэн хэмхэрсэн нэрээр дахин тоног төхөөрөмж авч төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах зэрэг сөрөг үр дагаварт хүргэж байна.

Багш нарт цахим сургалтын платформуудыг хэрхэн үр дүнтэй ашилах, тулгарч байгаа бэрхшээлүүдийг хэрхэн шийдэх зэрэг агуулгатай сургалтыг тогтмол давтамжтай зохион байгуулж, зөвлөн туслах: багш нарын мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалтуудад энэ тухай агуулгыг оруулах саналтай байна. Хичээл заадаг багш нар өөрчлөгдөнө, шинэ багш нар ажилд орж байна.

Цахим хэрэглээний зардлын төсөв, нөхөн хангалтын зардлын төсвийг төлөвлөх, хуваарилахдаа сургуулийн онцлогийг харгалзахаар тогтоол,

журамд өөрчлөлт оруулах: сургуулийн байршил, сурагчийн тоо, цахим дэд бүтцийн одоогийн нөхцөл байдал зэргийг харгалзан шаардлагатай төсвийг төлөвлөж, хуваарилдаг байвал эрх тэгш байдлыг илүү дэмжихээр байна.

Цахим дэлгүүрийн барааны нэр төрлийг нэмэгдүүлэх, үнэ болон чанарт анхаарах: үндсэндээ судалгаанд хамрагдсан бүх сургууль үүнийг хэлсэн.

Багш нарт датаны зардлыг үргэлжлүүлэн олгох: манай судалгаанд нийт 2,386 багш хамрагдсаны 87.1% нь хичээл, сургалтын үйл ажиллагаандаа зориулж дата авах зэргээр цахимтай холбоотой зардал өөрөөсөө гаргасаар байна гэж хариулсан. Тэдний 29.8% нь 10-20 мянган төгрөг, 29.2% нь 20-30 мянган төгрөгийн зардал гаргаж байгаа бол 10.5% нь 50 мянган төгрөгөөс их зардал гаргаж байна гэжээ. 2,386 багшийн 90.3% нь багш нарт олгож байсан 15,000 төгрөгийн дэмжлэгийг үргэлжлүүлэн олгохыг дэмжсэн. Гэхдээ багшийн заадаг хичээлийн төрөл /цахим платформ бүхий хичээл заадаг эсэх/, анги даасан эсэх зэрэг хүчин зүйлсийн харгалзан нийтээр нь хавтгайруулахгүй байдлаар зарцуулах хэрэгтэй байж болох юм.

ЦААШИД АНХААРАХ АСУУДЛУУД

Судалгааны үр дүн, санал зөвлөмжөөс урган гарч буй дараах асуудлуудад цаашид анхаарч, бодлогын болон хэрэгжилтийн түвшинд шийдэл гаргахыг зөвлөж байна. Үүнд:

- Цахим хэрэгсэл, интернет, датагүй байхгүйгээс суралцахуйн хоцрогдол үүсэх эрсдэлтэй байгаа сурагчдын асуудал
- Сургалтын удирдлагын мэдээллийн системийн ашиглалт, хэрэглээ эцэг эх, асран хамгаалагчдын дунд хангалтгүй байгаа асуудал
- Бага ангийн тэр дундаа 1, 2 дугаар ангийн сурагчдын цахим хэрэглээний асуудал /хажуугаар нь цахим тоглоом тоглох, хэвлэмэл сургалтын хэрэглэгдэхүүнээ анхаарахгүй байх/
- Цахим анги, танхимын эрүүл ахуй, ариун цэврийн асуудал /халдварт өвчлөл нэмэгдэж байгаа үед/
- Нөхөн хангалтын зардлаас тоног төхөөрөмж, цахим хэрэгслийн завсар, үйлчилгээ хийж, зардал гаргах боломжийн асуудал /төсвийн үр ашигтай ашиглалттай холбогдоно/

